



Thomas Jefferson Middle School

IBMYP Сонины 2-р сарын дугаар

Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа сурах нь.



Энэ сарын шилдэг сурагч: ТУНГААН БОДОГЧ

Бид бүх сурагчдаа **тунгаан бодогчид байгаасай гэж хүсэж байна**. Зохиолч Дан Виллингхам, “Ой санамж бол бодлын үлдэгдэл юм” хэмээн бичсэн байдаг. Сурагчид сурахын тулд сурч байгаа зүйлийнхээ талаар бүтээлчээр эсвэл няхуур байдлаар тунгаан бодох шаардлагатай. Бид сурагчдад тунгаан бодогчид байх боломж бүрдүүлсэн сурах үйл ажиллагаа болон үнэлгээ дүгнэлтийг тогтмол ашиглахыг зорьдог. Манай шилдэг тунгаан бодогч сурагчид бол: **Dolphins-Nora Mallet, Dragons-Nour Ben Hammouda, Eagles-Dhruva Barua, Gators-Chris Hunter, Monarch-Diana Rojas, Owls-Frances Shapiro, Penguins-Sean Memon, Phoenix-Bronwen Kubiack** болон **Stingrays-Katherine Velasco**. Эх сурвалж: [pixbay](#)



Бичгээр гаргасан сургалтын хөтөлбөр

Бие даан болон дугуйлан клубт, манай Дэлхийн Газарзүйн ангийн сурагчид зөрчилдөөн ба шийдэл сэдэвтэй, асуудалд суурилсан олон улсын бакалаврын сургалтыг дүүргэж байна. Сурагчид хамтран өнөөгийн дэлхий дахины олон улсын зөрчилдөөнд дүн шинжилгээ хийж, шийдэл санал болгодог. Тэд зөрчилдөөн гэж юу болох, яагаад зөрчилдөөн гардаг болохыг тодорхойлсон сэдвийг судалсан. Эрэн сурвалжилгаа дуусгасны дараа манай Газарзүйн ангийн сурагчид эргэн цуглаж, дэлхийн хамгийн хүндрэлтэй зөрчилдөөнийг (Афганистан, Хойд Солонгос г.м.) шийдвэрлэх дэлгэрэнгүй шийдлийг подкаст хэлбэрээр санал болгосон. Манай сурагчид зөрчилдөөн бүрд илүү сайхан ертөнцийг төсөөлөн цогцлоож байна.

Үнэлгээний журам: Зайлшгүй чухал тохиролцоо



Олон улсын бакалаврт 4 зайлшгүй баримтлах журам бий: 1) Хичээлийн шударга байдал, 2) Хэл, 3) Олон талт байдлын оролцоог хангасан байдал, 4) Үнэлгээ. Эхний гурвын хувьд бүгдийг энэ жил хянан шинэчилсэн. Одоо үнэлгээний журмыг боловсронгуй болгож эхлэх цаг ирлээ. Дунд бүлгийн хөтөлбөрт дүн тавих үйл явц **шударга, нэг мөр** болон **ил тод** байх шаардлага тавигддаг. Энэ нь дүнг гэрийн даалгавар, төсөл, сорил, шалгалт зэрэг хийсвэр категорид өгөхөөс илүүтэйгээр тодорхой нэг хичээлийн шалгуурт үндэслэн өгдөг байх ёстой гэсэн үг. Мөн үнэлгээ эргээд сурагчдад суралцах үйл явцынх нь талаар санал дүгнэлт өгдөг байвал зохихын зэрэгцээ тэднийг шинэ ойлголт, агуулгатай танилцаж байхад нь шийтгэдэггүй байвал зохино. Хэрэв та эдгээр санааг тусгасан үнэлгээний шинэ журам боловсруулах хорооны гишүүнээр ажиллахыг хүсвэл ноён Malinosky-д мэдэгдээрэй. Эх сурвалж: [pixbay](#)

ДБХ-ийн анги ба бодит үнэлгээ

Сурагчид хувиараа болон дугуйлан клуб, Хэл болон Уран зохиолын анги 2-р сарын 4-ний өдөр хотын захиргааны иргэдийн төлөөллийг хүлээн авлаа. Гүнлэгийн удирдах зөвлөлийн гишүүд Christian Dorsey, Erik Gutshall, сургуулийн удирдах зөвлөлийн гишүүд Tannia Talento, Monique O’Grady нийт 7-р ангийнхантай уулзаж Амазоны шинэ төв байраас эхлээд математикийн Dreambox хүртэлх орон нутагт болж өрнөж буй бүхий л сэдвээр хэлэлцлээ. Сурагчид сүүлийн нэг сарын хугацаанд оршин суугаа газрынхаа сонгогдсон албан тушаалтанд захиа бичсэн. Ингэхдээ Jefferson сургуулийн сурагчид хурц гярхай асуулт асуусан юм. Сургуулийн удирдах зөвлөл мэдээж гүнлэгийн удирдах зөвлөлөөс илүү олон асуултад хариулсан. Манай 7-р ангийнхан иргэний эрхээ эдэлж, ардчилал хэрхэн явагддагийг бодитоор харах боломжтой байв. Хатагтай Nolan-ы авсан гэрэл зураг.



Харилцааны Төслийн талаарх мэдээлэл

Харилцааны төслүүдийн үр дүнг харах цаг маш хурдан ойртож байна. Эцсийн хугацаа 4-р сарын 9. Манай 8-р ангийнхан энэ өдөр 6 болон 7-р ангийнханд орон нутагт тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд сонгосон зорилгын талаар танилцуулна. Одоо сурагчид үйлчилгээ, судалгаа, таниулан сурталчлах, ноцтой асуудлуудын талаар мэдээлэл өгөх зэргээр бодит шууд үйл ажиллагаа өрнүүлж байх ёстой цаг. Сурагчид үйл ажиллагааны хэсгээ дуусгасны дараа илтгэл дээрээ ажиллаж байх ёстой. Тодорхой нэг хүрээний хүмүүст туслах сорил бүхий зорилгоо хэрэгжүүлэхээр ажиллах явцдаа тэд юу сурч мэдэж авсан бэ? Сурч мэдэж авсан зүйлийг нь бид аль болох өргөн хүрээнд хуваалцахыг хүсэж байна. Эх сурвалж: [pixbay](#)



Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

ОУБ-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө бол сургуулийг байнга сайжруулахад нэн чухал баримт бичиг юм. Jefferson сургуулийн хувьд бид сүүлийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө дөрвөн жилийн өмнө ОУБ-ын сүүлийн үнэлгээний дараа боловсруулсан байдаг. Бид таван зөвлөмжид анхаарал хандуулж байгаа. 1) Олон нийтийн Төслийн талаарх ойлголт, 2) Сурах ур чадварын арга барилыг төлөвлөх, ашиглах, хэрэгжүүлэх, 3) Олон улсын агуулгын бүх 6 сэдвийн хувьд ДБХ-ийн төлөвлөх үйл явцыг бэхжүүлэх, 4) Хичээлийн төлөвлөгөө болон сэдвийн ерөнхий тоймд гол ойлголтуудыг багтаах ёстой, 5) Үйлчлэх хэлбэрээр суралцах нь үйлчлэлийн үр дүнгийн ойлголтуудтай нийцсэн байх ёстой. 6) Хичээл төлөвлөгчидтэй олон улсыг хамарсан асуудлууд уялдаж холбогдсон байх 7) Эрэн сурвалжлах, судлах ажилд олон улсын агуулга оруулах 8) ДБХ-ийн үнэлгээний шалгуурыг нэг мөр байдлаар ашиглах. Өөр санаа зовж буй асуудал байвал Ноён Malinosky-д мэдэгдээрэй.

Хар арьстнуудын түүхийн сар

Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

Jefferson сургуульд Хар арьстнуудын түүхийн сарыг 2-р сарын 13-ны өдөр Нүүдэл сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулагдлаа. Найрал дуучид Хар үндэстний сүлд дууг дуулсан. Тайз дээр хүүхэд бүр нүүдэлтэй холбоотой өөрт тохиолдсон явдлыг ярьсан. Langston Hughes болон Zora Neale Hurston нарын гайхалтай шүлгүүдийг уншсан. Мэргэжлийн дуучин “Зун цаг” дууг өвлийн тэсгэм хүйтэнд эргэн амилуулсан. Дараа нь сурагчид шударга бус байдлын эсрэг босож, өвдөглөн сууж Colin Kaerpernick-т хүндэтгэл үзүүлсэн. Энэ үнэхээр сайхан арга хэмжээ болсон. Гэрэл зургийг ноён Malinosky авсан.

- Лхагва гараг бүр номын санд олон нийтийн төсөлд туслах
- Мягмар гараг бүр 17:00 цагт унадаг дугуй засахад сайнд дураар туслах Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St
([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад сайн дураар туслах AFAC-т, 2708 S. Nelson St,
([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](#))
- [Сайн дурын ажлын хуваарь энд бий.](#)
- Сургуулиас зохион байгуулах бусад үйл ажиллагааны талаар мэдээлэл авах бол холбоотой байгаарай.